



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ХАРХОРИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 03 сарын 18 өдөр

Дугаар А/40

Хархорин сум


Тендерийн гүйцэтгэгчийг сонгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.1, 48 дугаар зүйлийн 48.2.4, Захиргааны ерөнхий хуулийн 43, 46 дугаар зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үнэлгээний хорооны хуралдааны 2025 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн 03 дугаар дүгнэлтийн дагуу ӨВАХХСЗДТГ/20250202001/01/01 урилгын дугаартай Засаг даргын Тамгын газарт тээвэр, шатахуун нийлүүлэх нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендерийг 72,982,713 (далан хоёр сая есөн зуун наян хоёр мянга долоон зуун арван гурав) төгрөгөөр “Сод Монгол групп”-ээр гүйцэтгүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Тендерт шалгарсан аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Х.Лхагвадулам)-д даалгасугай.

3. Гэрээнд заасан хуваарь гүйцэтгэлийн дагуу санхүүжилт олгохыг Төсвийн ерөнхий нягтлан бодогч (Ц.Мягмарсүрэн)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА  Б. БАТ-ЭРДЭНЭ

